



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/876

Ховд

Хөтөлбөр хэрэгжүүлж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Оросын Холбооны Улсын “Б.Б.Городовиковын нэрэмжит Халимаг Улсын Их сургууль”-ийн Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүсийн төв, Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу Халимаг Улсын Их сургуулийн болон Хөдөө аж ахуйн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлыг зохион байгуулан явуулсугай.

2. Халимаг Улсын Хөдөө аж ахуйн байгууллага болон “Б.Б.Городовиковын нэрэмжит Халимаг Улсын Их сургууль”-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах зардал, санхүүг гуравдугаар хавсралтаар баталсугай.

3. Халимаг Улсын Их сургуульд ажиллах ажлын айлчлалд шаардагдах 30,832,720 (Гучин сая найман зуун гучин хоёр мянга долоон зуун хорь) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 7.18 дахь Хүнсний хангамж - Аюулгүй байдал үндэсний хөтөлбөр төслөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



Zah A/876 Ba

8400001 2103

Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 01-ний өдрийн
А/875 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

ХАЛИМАГ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД АЖИЛЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: 1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Бүрэлдэхүүн: 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
3. Хүнс, хөдөө аж ахуйн газрын МҮА-ны дарга
4. Хүнс, хөдөө аж ахуйн газрын агрономич
5. Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн
6. Булган сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
7. Хувийн Мал үржлийн нэгжийн төлөөлөл
8. Хувийн Мал үржлийн нэгжийн төлөөлөл
9. Ховд Их сургуулийн төлөөлөл
10. Хөгжил политехник коллежийн Мал аж ахуй, газар тариалангийн тэнхимийн төлөөлөл
11. Орчуулагч
12. Жолооч

-оОо-